

From
the People of Japan



Зөвлөхийн тайлан

Төслийн нэр: МОН 9202: Улаанбаатар хотын хүнсний хаягдлыг дахин боловсруулах төсөл

Захиалагч: Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын Алба

Хамтран ажиллах зөвлөх үйлчилгээ: CS1- Хүнсний хаягдлыг дахин боловсруулах (Британий Стандартчилалын Байгууллага, Төв Азийн Хөрс Судлалын Холбооны түншлэл)

СУРГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн айл өрхүүдэд гэрийн нөхцөлд компост хийх аргазүйн сургалт

(Үйл ажиллагаа 2.7. Жижиг түвшний туршилтын төслийн хүрээнд сонгогдсон айл өрхүүдэд хүнсний хаягдлаар компост хийх болох хэрэглэх талаар сургалт)

2022 оны 5-р сар

АГУУЛГА

1. Үндсэн мэдээлэл	2
2. Сургалтын зорилго	2
3. Бэлтгэл ажил	2
4. Сургалтын хөтөлбөр	3
5. Хамрах хүрээ, үргэлжлэх хугацаа, байршил	5
6. Сургалтад оролцогсод	6
7. Сургалтын хэрэгжилт	6
8. Сургалтын үнэлгээ	7
8.1. Сургалтын үнэлгээ – Сонгинохайрхан дүүрэг.....	7
8.2. Сургалтын үнэлгээ – Чингэлтэй дүүрэг.....	11
9. Зохион байгуулалт, зардал	15
10. Дүгнэлт	16
Хавсралтууд	17
Хавсралт 1. Сургалт хэрэгжүүлэхийг хүссэн зөвшөөрөл ба Хэрэгжүүлэгч байгууллагын зөвшөөрөл.....	17
Хавсралт 2. Сургалтад оролцогсдын нэрсийн жагсаалт, бүртгэл.....	20
Хавсралт 3. Сургалтын хөтөлбөр.....	26
Хавсралт 4. Сургалтын материал.....	27
<i>MS PowerPoint танилцуулга</i>	27
<i>Зөвлөхийн бэлтгэсэн А4 хэмжээт гурван нугалбарт танилцуулга</i>	28
<i>Зөвлөхийн бэлтгэсэн А3 хэмжээт постер танилцуулга</i>	29
<i>ТХН-ийн бэлтгэн хэвлүүлсэн төслийн талаар брошур танилцуулга</i>	29
Хавсралт 5. Сургалтын дэлгэрэнгүй тайлан болон ТХН-ийн нэгтгэсэн тайлан.....	30

1. Үндсэн мэдээлэл

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (НЗДТГ), Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас (УБЗАА) Азийн хөгжлийн банктэй хамтран Ази, Номхон далайн бүсийн тогтвортой хөгжлийн Япон сангийн санхүүжилтээр "9202-МОН: Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл"-ийг хэрэгжүүлж байна.

Төслийн зорилго нь Улаанбаатар хотын хүнсний хаягдлын менежментийг сайжруулах, хүнсний хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, компост үйлдвэрлэх замаар дахин боловсруулдаг болох явдал юм. Хүнсний хаягдлаар компост үйлдвэрлэн газар тариалан, ногоон байгууламжид ашиглах нь бүтээмжийг нэмэгдүүлэх ба төслийн хүрээнд жижиг, дунд түвшний туршилтын төслүүдэд айл өрхүүд болон сургууль, цэцэрлэг зэрэг аж ахуйн нэгжүүд хамрагдан хүнсний хаягдал, түүнийг дахин боловсруулах талаар мэдлэг ухамсар нэмэгдүүлэх сургалтад хамрагдана.

Энэ хүрээнд ЗҮ1 зөвлөх баг Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 3-р хороо болон Чингэлтэй дүүргийн 7-р хорооноос урьдчилсан сонгосон тус бүр 25, нийт 50 өрхүүдэд хүнсний хаягдлын талаар болон жижиг түвшинд хүнсний хаягдал ашиглан компост хийх талаар практик сургалтыг төслөөс хүлээгдэх *Үр дүн II: Хүнсний хог хаягдлыг иргэдийн оролцоотой дахин боловсруулах арга ажиллагааг зааж сургах* ажлын хүрээнд 2.7-р үйл ажиллагаагаар 2022 оны 4-р сарын 29 болон 5-р сарын 9-ний өдрүүдэд тус тус зохион байгууллаа.

2. Сургалтын зорилго

Сонгогдсон айл өрхүүдэд дараах мэдлэг, туршлагыг олгоход энэхүү сургалтын зорилго оршино. Үүнд:

- Хүнсний хаягдлын талаар иж бүрэн мэдээлэл, мэдлэг олгох, тухайлбал хаягдлаас хэрхэн зайлсхийж болох, байгаль орчинд үзүүлдэг нөлөөг зэргийг тайлбарлан таниулах,
- Өрхийн хэмжээнд компостын хайрцаг ашиглан хүнсний хаягдлаар компост хэрхэн боловсруулахыг практик дээр үзүүлэн таниулах, мөн
- Компостыг юунд, хэрхэн ашиглах талаар мэдлэг олгох.

3. Бэлтгэл ажил

Зөвлөх баг энэхүү сургалтын Ажлын даалгавар (Termf of reference) болон холбогдох зардлын төсөвт тооцоог бэлтгэн 2022 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр Төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлсэн ба төсөвт зардалд багтсан 5 сая төгрөгийн төсөвт брошур хэвлэх зардлыг хассанаар Гүйцэтгэх байгууллагаас зөвшөөрлийг сургалт хэрэгжүүлэхээс өмнө ирүүлсэн болно. (Хавсралт 1).

4. Сургалтын хөтөлбөр

Дараахь ерөнхий хөтөлбөрийг зөвлөх баг боловсруулсан болно.

Хөтөлбөр	Сургалтын хэсгүүд	Ашиглах материал, хэрэгсэл
1 Танилцуулга	<ul style="list-style-type: none"> Албан бус танилцах хэсэг Бүртгэл, бэлтгэл ажил (ослын гарц, тамхигүй орчин, ариун цэвэр гм) Сургалтын хэлбэрийг танилцуулах Сургагч багш, зөвлөхийн танилцуулга Төслийн талаар товч танилцуулга Асуулт хариулт Хөтөлбөр, төлөвлөгөө ойлгомжтой эсэхийг баталгаажуулах 	Танилцуулах PPT танилцуулга <ul style="list-style-type: none"> Төслийн танилцуулга материал Хичээл, сургалтын зорилго Гарын авлага, тэмдэглэх дэвтэр зэргийг эко уутанд тарааж өгөх Хэвлэж бэлдсэн асуулгын маягт тараах
2 Хүнсний хог хаягдал	<ul style="list-style-type: none"> Хүнсний хаягдал гэж яг юу вэ? Хүнсний хаягдлыг төрлөөр нь үзүүлэх Хүнсний хаягдлын шинж чанар Бохирдол буюу бохирдуулагч материалууд гэж юу вэ? Бохирдлоос яагаад зайлхийх ёстой вэ? 	<ul style="list-style-type: none"> Хүнсний хаягдлын талаар богино видео үзүүлэх Хүнсний хаягдалтай хүмүүс хэрхэн харьцах вэ. Бохирдлыг тухай видео үзүүлэх буюу PPT Бохирдуулагч материалтай компостын талаар Асуулт, хариултын хэсэг
3 Хүнсний хаягдалтай холбоотой асуудал	<ul style="list-style-type: none"> Хүнсний хаягдлын байгаль орчинд үзүүлэх нөлөө, асуудлууд Хүнсний хаягдлыг булах нь байгаль орчинд хэрхэн нөлөөлдөг талаар 	<ul style="list-style-type: none"> Богино видео үзүүлж, тайлбарлах PPT танилцуулга Асуулт, хариулт
Завсарлагаа - 30 мин		
4 Компост бордоо хийх нь	<ul style="list-style-type: none"> Компост бордоо хийх аргын танилцуулга Компост бордооны үр ашиг Хүнсний хэрэглээний өсөлт хөрсний чанарын харилцан хамаарал 	<ul style="list-style-type: none"> Богино видео үзүүлж, тайлбарлах PPT танилцуулга PPT танилцуулга
5 Компостыг хайрцгаар хэрхэн хийх талаар	<ul style="list-style-type: none"> Компостыг хайрцгаар хийх аргын танилцуулга Хайрцгийг хэрхэн ашиглах вэ Боловсруулалтцы явцад үүсэх асуудал, бэрхшээлийг шийдэх нь 	<ul style="list-style-type: none"> Богино видеогоор тайлбарлах Бодит байдал дээр хийж үзүүлэх Суралцагчид өөрснөө турших Асуулт, хариулт
6 Компост бордоог хэрхэн ашиглах вэ	<ul style="list-style-type: none"> Компост гэж яг юу вэ Компостыг хэрхэн ашиглах вэ Компост бордооны болцыг хэрхэн, яаж мэдэх вэ Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны журмыг заавал мөрдөх нь 	<ul style="list-style-type: none"> Богино видеогоор тайлбарлах PPT танилцуулга Бодит байдал дээр компостын хайрцгаар компост хийж үзүүлэх
7 Сургалтын төгсгөл хэсэг	<ul style="list-style-type: none"> Өнөөдрийн сургалтаар бид юу сурч, мэдэв Асуулт, хариулт 	<ul style="list-style-type: none"> PPT танилцуулгыг дахин товч үзүүлэх Сургалтын дараахь санал асуулгыг бөглөх

Хөтөлбөрийн хэрэгжилт.

Танилцуулга хэсэгт багтсан Хөтөлбөрийн хуулбарыг Хавсралт 3-аас үзнэ үү.

2022 оны 4-р сарын 29-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 3-р хороо

Цаг	Үйл ажиллагаа
14:40 - 15:00	Бүртгэл, сургалтын өмнөх танилцуулга хэсэг
15:00 - 15:20	Нээлт <ul style="list-style-type: none"> • Б.Соёл-Эрдэнэ, СХД-ийн 3-р хорооны Засаг дарга; • Р.Ганбаяр, СХД-ийн Агаарын бохирдолтой тэмцэх хэлтсийн Орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн; • Ч Лхагвадулам, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч
15:20 - 15:50	Үндсэн ойлголт, мэдээлэл өгөх танхимын сургалт. Жэйн Гилберт, зөвлөх багийн ахлагч, олон улсын зөвлөх. <ul style="list-style-type: none"> • Хүнсний хаягдлын тухай ойлголт; • Хүнсний хаягдалтай холбоотой үүсдэг асуудлууд; • Компост бордооны тухай ойлголт
15:50 - 16:10	Цайны завсарлага (Фото зураг авахуулах)
16:10 - 16:40	Компост боловсруулах практик сургалт Жэйн Гилберт, зөвлөх багийн бусад мэргэжилтнүүдийн хамт. <ul style="list-style-type: none"> • Жижиг түвшинд хайрцаг ашиглан хүнсний хаягдлаар компост хийх заавар; • Компост бордооны хэрэглээ, ашиглалт
16:40 - 17:00	• Асуулт, хариулт
17:00 - 17:30	• Хаалт, сургалтын дараах үнэлгээ

2022 оны 5-р сарын 09-ны өдөр Чингэлтэй дүүргийн 7-р хороо

Цаг	Үйл ажиллагаа
14:40 - 15:00	Бүртгэл, сургалтын өмнөх танилцуулга хэсэг
15:00 - 15:20	Нээлт <ul style="list-style-type: none"> • Б.Ерөө, ЧД-ийн 7 дугаар хорооны Засаг дарга • Ч Лхагвадулам, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч
15:20 - 15:50	Үндсэн ойлголт, мэдээлэл өгөх танхимын сургалт. Жэйн Гилберт, зөвлөх багийн ахлагч, олон улсын зөвлөх. <ul style="list-style-type: none"> • Хүнсний хаягдлын тухай ойлголт; • Хүнсний хаягдалтай холбоотой үүсдэг асуудлууд; • Компост бордооны тухай ойлголт
15:50 - 16:10	Цайны завсарлага (Фото зураг авахуулах)
16:10 - 16:40	Компост боловсруулах практик сургалт Жэйн Гилберт, зөвлөх багийн бусад мэргэжилтнүүдийн хамт. <ul style="list-style-type: none"> • Жижиг түвшинд хайрцаг ашиглан хүнсний хаягдлаар компост хийх заавар; • Компост бордооны хэрэглээ, ашиглалт
16:40 - 17:00	• Асуулт, хариулт
17:00 - 17:30	• Хаалт, сургалтын дараах үнэлгээ

5. Хамрах хүрээ, үргэлжлэх хугацаа, байршил

Дээрх хөтөлбөрийн дагуу сургалтыг танхимаар болон практик сургалтаар хослуулан хэрэгжүүлсэн ба 4-р сарын 29-ний Сонгинохайрхан дүүргийн 3-р хорооны 25 айл өрхийн сургалтыг тухайн хорооны иргэний танхимд, харин 5-р сарын 09-ний Чингэлтэй дүүргийн 7-р хорооны 25 айл өрхийн сургалтыг мөн хорооны иргэний танхимд тус тус хагас өдрийн турш зохион явууллаа.



СХД-ийн 25 өрхийн компостын сургалт, 2022 оны 4-р сарын 29



ЧД-ийн 25 өрхийн компостын сургалт, 2022 оны 5-р сарын 09

Айл өрхүүдэд, тухайн хорооны удирдлага болон ТХН-ийн дэмжлэгтэйгээр хамтран хэрэгжүүлсэн энэхүү сургалт нь иргэдэд хүнсний хаягдал болон түүгээр компост хийх аргын талаар дэлгэрэнгүй танилцуулсан, Улаанбаатар хотын хүнсний хаягдлыг дахин боловсруулах төслийн хүрээнд жижиг, дунд, том түвшний туршилтын төслийн шууд оролцогч нарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн сургалтуудын анхных юм.

Зөвлөх багийн ахлагч Жэйн Гилберт сургалтын хөтөлбөр, танилцуулга болон холбогдох бусад материалыг бэлтгэн өөрийн биеэр Улаанбаатар хотод ажилласан өдрүүдэд уг сургалтыг зохион байгуулсан нь сургалтыг илүү үр дүнд хүргэх ач холбогдолтой байлаа.

6. Сургалтад оролцогсод

Сонгинохайрхан дүүргийн 3-р хорооны 25 өрх айл сургалтад хамрагдахаа урьдчилсан илэрхийлсэн боловч 22 айлын төлөөлөл сургалтад ирсэн ба нийт оролцогчдын 90% эмэгтэй байв. Насны хувьд 55-аас дээш насны оролцогч 45%, 45-54 насны оролцогч 31 %, бусад насны оролцогч 24% байлаа. Оролцогчдын ихэнхи нь буюу 13 нь тэтгэвэртээ гарсан, 5 нь тодорхой ажил хөдөлмөр эрхэлдэг, 1 нь хувиараа бизнес эрхэлдэг, 2 нь группт байдаг бол 4 нь тодорхой эрхэлсэн ажилгүй байна

Сургалтад айл өрхийн төлөөллөөс гадна, дүүргийн албаны хүмүүс буюу СХД-ийн 3-р хорооны засаг дарга, хэсгийн ахлагч, агаарын дүүргийн бохирдолтой тэмцэх хэлтсийн орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн болон Төсөл хэрэгжүүлэх нэгжийн төлөөллөөс бүрдсэн бүрдсэн нийт 37 хүн хамрагдлаа.

Чингэлтэй дүүргийн 7-р хорооны 25 өрх айл сургалтад хамрагдахаа мэдэгдсэн боловч сургалтын өдөр 21 өрхийн төлөөлөл ирэв. Хэдийгээр, сургалтад оролцогчдын хүйсийн харьцаанд эрэгтэйчүүд 14, эмэгтэйчүүд 7 буюу эмэгтэйчүүдийн эзлэх хувь 33% байсан ч айл өрхүүдээр биечлэн явж танилцахад хүнсний хаягдлаа ангилах, компостын хайрцганд хийж хутгах зэрэг үйл ажиллагааг гэр бүлийн эмэгтэй гишүүд зонхилон (80 хүртэл хувь) хийж байгаа нь ажиглагдсан болно.

Сургалтад мөн 3-р хорооны засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нар болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд зэрэг нийт 37 оролцогч хамрагдлаа. Нийт оролцогчдын 43% нь 55-аас дээш насны, 19% нь 35-44 насны, 9% нь бусад насны оролцогчид байв. Нэг өрх дундчаар 4 ам бүлтэй бөгөөд судалгаанд оролцогчдын 61% нь хоол хүнсэндээ сарын орологынхоо 51-70 хувийг зарцуулдаг байна. Оролцогчдын ихэнхи нь буюу 16 нь (76%) тэтгэвэртээ гарсан, 6 нь (28%) тодорхой ажил хөдөлмөр эрхэлдэг, 4 нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг бол 1 нь одоогоор ажилгүй байна.

Сургалтад оролцогчдын нэрсийн жагсаалтыг Хавсралт 2-оос харна уу.

7. Сургалтын хэрэгжилт

Сонгинохайрхан дүүргийн 3-р хороонд сургалтын үйл ажиллагааг нээж тус хорооны засаг дарга Б.Соёл-Эрдэнэ, СХД-ийн Агаарын бохирдолтой тэмцэх хэлтсийн орчны бохирдлын мэргэжилтэн Р.Ганбаяр нар үг хэлсэн бол Чингэлтэй дүүргийн 7-р хорооны сургалтыг нээж хорооны засаг дарга Б.Ерөө үг хэллээ. Эдгээр хороонуудын засаг дарга нар сургалтыг нээж үг хэлсний дараа Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч Ч.Лхагвадулам төслийн зорилго, зорилт, хүнсний хог хаягдлыг компост бордоо болгон хувиргахын ач холбогдлын талаар танилцуулав.

Сургалтыг нээлтийн дараа хөтөлбөрийн дагуу, компост бордооны мэргэжилтэн Др Жэйн Гилберт хүнсний хаягдал, түүний төрөл, байгаль орчинд үзүүлдэг нөлөө болон хүнсний хаягдлаас үүдэн гардаг бусад асуудлууд, шийдвэрлэх арга замын талаар болон бага оврын хайрцаг ашиглан хүнсний хаягдлаар гэрийн нөхцөлд хэрхэн компост хийх арга зүйн хичээлийг танхимын сургалтаар заав. Сургалтын явцад оролцогчдын идэвхитэй оролцоог хангахын тулд аль болох асуулт, хариултын хэсгүүдийг шаардлагатай газруудад оруулж өгсөн болно.

Танхимын сургалтын дараа зөвлөх баг бүх оролцогчдод бага оврын хайрцаг болон дагалдах хэрэгсэл (гар хүрз, термометр) албан ёсоор хүлээлгэн өгсөн.

8. Сургалтын үнэлгээ

Сургалтын үнэлгээг хоёр хэлбэрээр явуулахаар төлөвлөсөн ба эхний хэсэг нь хүнсний хаягдал болон хаягдлын менежментийн талаар сургалтад оролцогчдоос мэдээлэл авах зорилгоор буюу мэдлэгийн түвшинг тандан үнэлэх (сургалтын өмнөх үнэлгээ) зорилготой бол сургалтын дараа сургалтын чанар, үр дүнг мөн тэднээр үнэлүүлсэн (сургалтын дараах үнэлгээ) болно.

8.1. Сургалтын үнэлгээ – Сонгинохайрхан дүүрэг

Сургалтын өмнөх үнэлгээ, СХД

1. Сургалтад оролцогчдоос хог хаягдлын менежментэд хандах хандлагын талаар мэдээлэл авах зорилгоор асуумжаар авсан мэдээллийг гол үр дүн:

- СХД-ийн нийт оролцогчийн 65 % нь эх үүсвэр дээр гарч буй хог хаягдлаа ангилан ялгадаг ба ангилан ялгасан хог хаягдлаас ихэвчлэн хуванцар сав, гялгар уутыг (72%) эргүүлэн ашиглах эсвэл хоёрдогч түүхий эдийн төвд тушаадаг бол хоолны үлдэгдлийг нохойдоо (30%) өгөх зорилгоор дахин ашигладаг байна.
- Хог хаягдлыг хаях, ангилан ялгах зэрэг ажлыг ихэвчлэн эмэгтэйчүүд (54%) хариуцдаг ч гэр бүлийн гишүүд хоёулаа (44%) ч мөн оролцдог гэж хариулсан.
- Харин хог хаягдлаа ангилан ялгадаггүй шалтгааныг, 45% нь хог хаягдал ангилан ялгах үйлдвэр байхгүй, бүх хогийг хольж ачдаг, 40% нь зав байдаггүй гэсэн байна.
- Хэрэв хог хаягдлаа ангилан ялгахгүй байвал байгаль орчинд сөргөөр нөлөөлөх үү гэсэн асуултад бүх оролцогчид буюу (100%) нь тийм гэж санал нэгтэй хариулжээ.
- Сөрөг нөлөөний талаар тэдний мэдлэгийг тандан асуухад 68% нь гялгар уут, нийлэг бүтээгдэхүүн хөрсөнд сөргөөр нөлөөлнө, 41% нь агаар, орчны бохирдол, халдварт өвчин үүсгэнэ, 36% нь хүлэмжийн хий ялгаруулна, 31% нь бактерийн бохирдол үүснэ гэж хариулсан.

2. Хүнсний хог хаягдлын менежменттэй холбоотой асуумжийн хариултыг дүгнэвэл:

- Хүнсний бүтээгдэхүүнд худалдан авахад оролцогчдын 60% нь сарын орлогын 51-70%-ийг зарцуулдаг гэсэн байна.
- Мөн оролцогчдоос тэдний хүнсний хэрэглээний хэмжээ, бүтэц өвөл, зун улиралд хэр ялгаатай байдгийг асуухад 48% нь хэрэглээнд онцын ялгаа байдаггүй, 43% нь ялгаа бий гээд, тухайлбал өвөл мах их хэрэглэдэг гэсэн байна.
- Хүнсний хаягдлын бүтцийн хувьд нийт оролцогчийн 72% нь үлдэгдэл мах, яс, 54% нь хоолны үлдэгдэл, 9% хүнсний ногооны хаягдал гардаг гэж хариулсан байна.
- Хүнснээс хаягдлаас тэр дундаа хоолны үлдэгдлээ хэрхэн шийдвэрлэдэг талаар асуухад 70% нь бусад хог хаягдалтай нийлүүлж хаядаг гэж хариулжээ.
- Хүнсний хаягдал нь компостын үнэ цэнэтэй түүхий эд гэдгийг нийт оролцогчдын 63% мэднэ гэж хариулсан байна.

Сургалтын дараахь үнэлгээ, СХД

Сургалтын дараах үнэлгээ нь сургалтын чанар, зохион байгуулалтад өгөх үнэлгээ, мөн сургалтаас олж авсан мэдлэгийн хэмжээг сургалтаас өмнөх мэдлэгтэй харьцуулсан үнэлгээнээс бүрдэнэ.

1. Сургалтын зохион байгуулалт, чанарын үнэлгээ

Сургалтын чанар, зохион байгуулалтын хувьд Сонгинохайрхан дүүргийн 3-р хорооны бүх оролцогчид сайн буюу маш сайн гэсэн үнэлгээ өгсөн. Тухайлбал, сургалт явуулсан зөвлөхүүдийн заах арга барил, ур чадвар, мөн сургалтад хамрагсдын хүлээлтэд уг сургалт нийцсэн байдалд тэд санал нэгтэй хамгийн сайн оноог өгсөн байна. Түүнчлэн, сургалтад зориулан зөвлөхүүдийн бэлдсэн материалууд, ашигласан жишээ, гарын авлага зэргийг 80-90%-ийн түвшинд үнэлсэн бөгөөд сургалтын ерөнхий зохион байгуулалт маш сайн гэдэг ерөнхий үнэлгээг санал нэгтэй өгчээ.

Сургалтын дараах асуумжийн хариултын нэгдсэн дүн


Хэсэг-1.Сургалтын чанар	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн
	1	2	3	4	5
A. Сургагч багшийн заах арга барил, ур чадвар					100%
B. Сургалт таны хүлээлтэд хүрсэн үү					100%
C. Онолын мэдлэг олгосон байдал				10%	90%
D. Сэдвийн хүрээнд сургагч багшийн мэдлэгийн түвшин				10%	90%
E. Сургалтын үргэлжлэх хугацаа хэр нийцтэй байв				20%	80%
F. Сургалтын материал хэр ойлгомжтой байв				20%	80%
G. Сургалтад ашигласан жишээ, дасгалын хангалттай байдал				14 %	86%
H. Сургалтын чанар, сургалт хэр ойлгомжтой байв				10%	90%
I. Сургалтын гарын авлага				20 %	80%
Хэсэг-2.Зохион байгуулалт					
J. Сургалтын танхим, тоног төхөөрөмж, хэрэгсэл					100%
K. Ерөнхий зохион байгуулалт				10%	90%

2. Сургалтын дараа олж авсан мэдлэгийн харьцуулсан үнэлгээ


СХД-ийн 3-р хорооноос сургалтад оролцогчдын мэдлэгийн түвшинтэй байсныг тандах зорилгоор асуусан асуултуудыг сургалт явуулсны дараа дахин асууж тэдний мэдлэг, ойлголт хэр нэмэгдсэнийг харьцуулсан судалсан юм. Харьцуулсан үнэлгээг диаграммаар харуулав.



4. Харин та одоо хог хаягдлаа ангилан ялгаж дахин боловсруулахад бэлэн үү?



5. Хүнсний хаягдал нь компост бордооны үнэ цэнэтэй түүхий эд гэдгийг Та мэдэх үү?



8.2. Сургалтын үнэлгээ – Чингэлтэй дүүрэг

Сургалтын өмнөх үнэлгээ, ЧД

1. Сургалтад оролцогчдоос хог хаягдлын менежментэд хандах хандлагын талаар мэдээлэл

Хог хаягдлын менежментийн хандлагын талаарх асуумжийг дүгнэвэл:

- Чингэлтэй дүүргийн нийт оролцогчийн 50% нь эх үүсвэр дээр гарч буй хаягдлаа ангилан ялгадаг ба ангилан ялгасан хог хаягдлаас ихэвчлэн хуванцар сав, гялгар уутыг (50 %) эргүүлэн ашиглах эсвэл хоёрдогч түүхий эдийн төвд тушаадаг бол цаас болон картонон хайрцгийг (26%), хоолны үлдэгдлийг (19%) тус тус ангилан, дахин ашигладаг байна.
- Хог хаягдлыг хаях, ангилан ялгах үүргийг ихэвчлэн эмэгтэйчүүд (16 эмэгтэй буюу 61%) гүйцэтгэдэг бол, 34 % нь хоёулаа оролцдог хэмээн хариулжээ.
- Хаягдлаа ангилан ялгадагүй шалтгааныг асуухад нийт оролцогчдын 27% нь хог хаягдал ангилан ялгах нь төвөгтэй, 23% ангилан ялгах, хадгалах сав, газар байхгүй мөн 23% хаягдлыг дахин боловсруулдаг газар байхгүй, хогийн цэгийн бүх хог хаягдал холилдсон байдаг гэж хариулсан байна.
- Хэрэв хог хаягдлаа ангилан ялгахгүй байвал байгаль орчинд сөргөөр нөлөөлөх үү гэсэн асуултад нийт оролцогчид (26 оролцогч буюу 100%) тийм гэж хариулсан байна.
- Ямар сөрөг нөлөөтэй талаар асуухад 42% нь агаар, орчны бохирдол, халдварт өвчин үүсгэнэ, 27% нь гялгар уут, нийлэг бүтээгдэхүүн хөрсөнд сөргөөр нөлөөлнө, 16% бактерийн бохирдол үүсгэнэ, 10% нь хүлэмжийн хий ялгаруулна гэж тус тус хариулсан.

2. Хүнсний хог хаягдлын менежменттэй холбоотой асуумжийн хариултыг дүгнэвэл:

- Хүнсний бүтээгдэхүүний худалдан авалтад нийт оролцогчдын 16 нь буюу 61% нь сарын орлогынхоо 51-70% хүнсэндээ зарцуулдаг гэсэн байна.
- Мөн оролцогчдын хүнсний хүнсний хэрэглээ улирлын ялгаатай байдаг эсэх талаар асуултад 61% нь ялгаатай гээд, тухайлбал 38% нь зун, намрын улиралд сүү, сүүн бүтээгдэхүүн түлхүү, харин 23% зун, намрын улиралд жимс, хүнсний ногоо илүү хэрэглэдэг гэж хариулсан.
- Өрхөөс үүсч буй хүнсний хаягдлын хувьд нийт оролцогчийн 31% нь гэрээс нь хүнсний ногооны (төмсний, луувангийн, сонгино, сармисны хальс) хальс ихээр гардаг гэж хариулсан байна. Хоолны үлдэгдлийг хэрхэн шийдвэрлэдэг талаар асуухад 58% нь нохой, тэжээвэр амьтандаа өгдөг, 33% нь бусад хог хаягдалтай нийлүүлэн хаядаг гэж хариулсан байна.
- Хүнсний хаягдал нь компостын үнэ цэнэтэй түүхий эд гэдгийг нийт оролцогчдын 46% мэднэ гэж хариулсан байна.

Сургалтын дараахь үнэлгээ, ЧД

1. Сургалтын зохион байгуулалт, чанарын үнэлгээ


Сургалтын чанар, зохион байгуулалтын талаар Чингэлтэй дүүргийн 7-р хорооны бүх оролцогчид сайн буюу маш сайн гэсэн үнэлгээ өгсөн. Тухайлбал, сургалт явуулсан зөвлөхүүдийн заах арга барил, онолын мэдлэгийн түвшин, бэлтгэсэн сургалтын материалын ойлгомжтой байдал, ашигласан жишээ, дасгалын хангалттай байдал зэрэгт тэд хамгийн сайн оноог өгсөн байна.

Сургалтын дараах асуумжийн хариултын нэгдсэн дүн


Хэсэг-1.Сургалтын чанар	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн
	1	2	3	4	5
A. Сургагч багшийн заах арга барил, ур чадвар				12%	88%
B. Сургалт таны хүлээлтэд хүрсэн үү				30%	70 %
C. Онолын мэдлэг олгосон байдал				24%	86 %
D. Сэдвийн хүрээнд сургагч багшийн мэдлэгийн түвшин				6 %	94 %
E. Сургалтын үргэлжлэх хугацаа хэр нийцтэй байв				17%	83 %
F. Сургалтын материал хэр ойлгомжтой байв				6%	94 %
G. Сургалтад ашигласан жишээ, дасгалын хангалттай байдал				12%	88%
H. Сургалтын чанар, сургалт хэр ойлгомжтой байв				12%	88%
I. Сургалтын гарын авлага				35%	65%
Хэсэг-2. Зохион байгуулалт					
J. Сургалтын танхим, тоног төхөөрөмж, хэрэгсэл				12%	88%
K. Ерөнхий зохион байгуулалт				23%	77%

2. Сургалтын дараа олж авсан мэдлэгийн харьцуулсан үнэлгээ


Сургалтад оролцогчдын мэдлэгийн түвшинтэй байсныг тандах зорилгоор асуусан асуултуудыг сургалт явуулсны дараа дахин асууж тэдний мэдлэг, ойлголт хэр нэмэгдсэнийг харьцуулсан судалсан юм. Харьцуулсан үнэлгээг диаграммаар харуулав



4. Та одоо хог хаягдлыг ялган дахин боловсруулахад бэлэн үү?



5. Хүнсний хаягдал нь бордооны үнэ цэнэтэй түүхий эд гэдгийг та мэдэх үү?



9. Зохион байгуулалт, зардал

Энэ үйл ажиллагааны бэлтгэл ажилд багагүй цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулагдсан ба хэрэгжилтийг багийн ахлагч болон дэд ахлагчийн удирдлага дор нягт нямбай зохион байгууллаа.



Үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвшөөрөл болон холбогдох төсвийг Гүйцэтгэх байгууллага уг ажлыг хэрэгжүүлж эхлэхээс өмнө цаг хугацаанд нь өгсөн болно. Зарцуулах төсвийн төслийг 4-р сарын 11-нд ТХН-д хүргүүлсний ТХН-ийн зохицуулагч 1,000 хувь хэвлэх брошурын хэвлэлийн зардал болох 5 сая төгрөгийн зардлыг хасах санал гаргасны дагуу шинэчилсэн төсвөөр батлагдсан төсвийн хүрээнд сургалтыг амжилттай хэрэгжүүллээ. Эна талаар мэдээллийг Хавсралт 1-ээс үзнэ үү.

Хэдийгээр зардлын шугамуудын зарим нь бодит хэрэгжилт дээр хэтэрсэн ч, заримын зарцуулалт бага байсан бөгөөд нийт төсөвт багтаан доорхи хүснэгтэд үзүүлсэнчлэн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн болно. Зардал бүрийн төлбөрийн баримт болон холбогдох бусад материал бүхий санхүүгийн тайланг нэхэмжлэхийн хамт тусад нь ТХН-д хүргүүлэх болно.

	төсөв	батлагдсан	зарцуулсан	үлдэгдэл
Цайны завсарлага, цай, кофе	₮ 800,000	₮ 800,000	₮ 293,700	₮ 506,300
Сургалтын танхимын түрээс	₮ 800,000	₮ 800,000	₮ 300,000	₮ 500,000
Хэвлэл 1 (брошур 1000 хувь)	₮ 5,000,000	₮ 0	₮ 0	₮ 0
Хэвлэл 2, 3 (сургалтын материал, постер)	₮ 1,050,000	₮ 1,050,000	₮ 515,000	₮ 535,000
Бусад зардал (эко уут, үзэг, дэвтэр гм)	₮ 900,000	₮ 900,000	₮ 362,080	₮ 537,920
Субстратын бүрэлдэхүүн материал	₮ 2,334,700	₮ 2,334,700	₮ 3,865,089	-₮ 1,530,389
	₮ 10,884,700	₮ 5,884,700	₮ 5,335,869	₮ 548,831

10. Дүгнэлт

Жижиг түвшинд компост хийх туршилтын төслийн 2.7-р үйл ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 3-р хороо, Чингэлтэй дүүргийн 7-р хорооноос сонгогдсон нийт 50 айл өрхүүдэд хүнсний хаягдал талаар болон хүнсний хаягдал ашиглан компост боловсруулах сургалтыг хоёр тусдаа хэрэгжүүлсэн нь маш амжилттай хэрэгжсэн гэж зөвлөх баг дүгнэж байна.

Сургалтын тайланг 2022 оны 5-р сарын 30-нд дэлгэрэнгүй хэлбэрээр хоёр дүүрэг тус бүрт дэлгэрэгүй хэлбэрээр хүргүүлсэн бас ТХН-ийн саналыг тусган эцэслэсний дараа ТХН-ээс нэгдсэн байдлаар гаргасныг Хавсралт 5-аас үзнэ үү. Тухайн тайланд сургалтын хэрэгжилтийн дүгнэлт, зөвлөмж, цаашид авах арга хэмжээг дэлгэрэнгүй тусгасан болно.







Сонгинохайрхан дүүргийн сургалтын практик ажиллагааны үеэр



Чингэлтэй дүүргийн сургалтын практик ажиллагааны үеэр

Хавсралтууд

Хавсралт 1. Сургалт хэрэгжүүлэхийг хүссэн зөвшөөрөл ба Хэрэгжүүлэгч байгууллагын зөвшөөрөл

<p>DocuSign Envelope ID: 0249D3F1-58DC-430D-8BB7-DD174086CE5D</p> <p>bsi. Inspiring trust for a more resilient world.</p> <p>Project Implementation Unit Lkhagvadulam Chimeddamba, Project Coordinator MSN Building, Unit 503, Mahatma Gandhi Street 15th Khoroo, Khan-Uul District 17011 Ulaanbaatar, Mongolia</p> <p>London, 11 April 2022 8:47 PM BST</p> <p>Your ref: MON 9202 - Ulaanbaatar Community Food Waste Recycling: Package CS1. Consultancy Services Subject: Request No.2 for approval of mobilisation of funds from Provisional sums</p> <p>Dear Ms Lkhagvadulam Chimeddamba,</p> <p>We hereby request the approval of funding from the provisional sums to undertake the activity described in the ToR attached in Annex 1.</p> <p>The purpose of the activity is to inform householders about food waste, how to use the box composter and how to use compost.</p> <p>The estimated budget is enclosed in the Annex 2.</p> <p>Yours sincerely,</p> <p>DocuSigned by: <i>Tumennasan Dolgor</i> 00AAE0005972454</p> <p>Tumennasan Dolgor Lead Project Manager, International Projects The British Standards Institution (BSI)</p> <p>Enclosed: Annex 1. Terms of Reference of the proposed activity Annex 2. Estimated budget</p> <p>The British Standards Institution Incorporated by Royal Charter Principal office: 389 Chiswick High Road London, W4 4AL, United Kingdom Companies House number: ZC0202</p> <p>  </p>	<p>DocuSign Envelope ID: 0249D3F1-58DC-430D-8BB7-DD174086CE5D</p> <p>bsi. Inspiring trust for a more resilient world.</p> <p>Annex 1. Terms of Reference of the proposed activity</p> <p>Training of 50 Selected Householders in Ulaanbaatar's Ger Areas</p> <p>1. PURPOSE</p> <ul style="list-style-type: none">To inform householders about:<ul style="list-style-type: none">Food wasteHow to use the box composter; andHow to use compost <p>2. LEARNING OUTCOMES</p> <ul style="list-style-type: none">To understand how food waste is generated and the different typesTo understand the problems it causes when landfilledTo know how to separate food waste and prevent contaminationTo know how to use the box composterTo know how to evaluate and use compost <p>3. SCOPE OF SERVICES</p> <ul style="list-style-type: none">Two training sessions (one in each of the selected khoros)To be held during April /early May 2022Half a day for each training session <p>4. FORMAT</p> <ul style="list-style-type: none">Face-to-faceInteractive with Q&AsSome short online videos (e.g. of food waste problems)Practical demonstrations using food waste and boxSimple techniques to evaluate compost quality and how to use it <p>5. OUTLINE SYLLABUS/AGENDA & TIMINGS</p> <ul style="list-style-type: none">Welcome & introductions (20 mins)Baseline questionnaireDemonstration of the different types of food waste, how to prevent contamination & discussions about it (20 mins)Introduction to problems associated with food waste. Videos and discussions (20 mins)Very simple introduction to composting and its benefits. Videos and discussions (20 mins)Demonstration of how to use the box composter. Practical and include leaflet with instructions. (20 mins)Demonstration of how to evaluate compost quality. Practical and video with instructions. (20 mins) <p>The British Standards Institution Incorporated by Royal Charter Principal office: 389 Chiswick High Road London, W4 4AL, United Kingdom Companies House number: ZC0202</p> <p>  </p> <p>05 ↑↓</p>
--	--

DocuSign Envelope ID: 0249D3F1-58DC-430D-8BB7-DD174086CE5D



Inspiring trust for a more resilient world.

- Wrap up, including any additional questions/discussion etc. (30 mins)
- Final questionnaire

6. EQUIPMENT & CONSUMABLES

- Equipment such as laptop, projector and white screen or large monitor
- A1 Flip chart, flip chart pens
- Samples of the different types of food waste
- Samples of the types of contaminants (e.g. plastics etc.)
- Box composters x 2
- Handheld trowels x 2
- Samples of compost
- Samples of composting materials
- Cloths (to wipe down surfaces)
- Disposable bags
- Sanitizing hand gel
- Compost quality test:
 - Small flowerpots or milk cartons (x5). If milk cartons are used scissors are needed
 - Soil and sand (about 5 L each)
 - Compost to be tested
 - Tray of 30 (W) x 50 (L) x 15 (H) cm (x1)
 - Bucket 10-20 L (x1)
 - Seedlings (lettuce, spinach)
 - Permanent marker (x1)
 - Water
- Tea and coffee
- Stationery (note pad and pen in an eco-bag)



The British Standards Institution
 Incorporated by Royal Charter
 Principal office: 389 Chiswick High Road London, W4 4AL, United Kingdom
 Companies House number: 200202



DocuSign Envelope ID: 0249D3F1-58DC-430D-8BB7-DD174086CE5D



Inspiring trust for a more resilient world.

Annex 2. Training of 50 Selected Householders in Ulaanbaatar's Ger Areas

Cost items	times	quantity	unit cost	total cost in MNT	total in USD*
Coffee and tea. For up to 40 x 2	2	40	₮ 10,000	₮ 800,000	USD 265
Conference room rent. 1/2-day x 2	2	4	₮ 100,000	₮ 800,000	USD 265
Printing material 1 (3-fold leaflets in A4)		1,000	₮ 5,000	₮ 5,000,000	USD 1,654
Printing material 2 (handouts in A4) 150 x 15pp		150	₮ 5,000	₮ 750,000	USD 248
Printing material 3 (poster) A3 size x 100		100	₮ 3,000	₮ 300,000	USD 99
Stationery (pen, notebook, in an eco-bag)		60	₮ 15,000	₮ 900,000	USD 298
Ingredients to use in the training**				₮ 2,334,700	USD 772

***USD 3,601

**Ingredients for 55 Households

Materials	amount	unit cost	Line costs (MNT)
Salty solution			
Water (litre)	4		n/a
Salt (kg) 50 gr per HH (50gr x 55 = ~3 kg in total)	3	₮ 3,600	₮ 10,800
Fruit peels/vegetables leaves (kg)	0.75	n/a	
Bucket - recipient (5 L)	1	n/a	n/a
Plastic bags to cover the solution	1	₮ 100	₮ 5,500
Sweet solution			
Water (litre)	4	n/a	n/a
Yogurt (ml), 750ml per HH (750ml x 55 = ~42 litres)	42	₮ 3,500	₮ 147,000
Sugar (kg), 100 gr per HH (100gr x 55 = ~5.5kg)	5.5	₮ 7,000	₮ 385,000
Yeast (kg) 1 pack (10 gr) per HH	55	₮ 600	₮ 33,000
Beer (litre) 300ml per HH (0.3 x 55 = 16.5 l)	33.0	₮ 2,500	₮ 137,500
Bucket - recipient (5 litres)	1	n/a	n/a
Plastic bags	1	₮ 100	₮ 5,500
Substrate			
Draff/semolina (kg) 5kg per HH	275	₮ 3,000	₮ 825,000
Rice husk (kg) 5kg per HH	275	₮ 2,800	₮ 770,000
Tree leaves (kg)		n/a	n/a
Crushed charcoal(kg) 1kg per HH	55	₮ 280	₮ 15,400
			₮ 2,334,700
			USD 772



* exchange rate used in this table will be the rate of the day before the request date.
<https://www.xe.com/currencytables/>

April 10, 2022 3,023.02

